

2024 оны 5 сарын 15

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй үр дүнтэйгээр тэмцэх нь

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) чиглэлээр суурь мэдлэг олгох сургалтаар МУТСТ-ын хүрээнд хөндөгддөг үндсэн ойлголтуудыг дэлгэрүүлэн авч үзэхийн сацуу Мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн практикт авч хэрэгжүүлж шаардлагатай арга хэмжээний талаар шаардлагатай суурь мэдлэгийг олгох болно.

Сургалтын хөтөлбөр

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ойлголт** (үе шат, сөрөг нөлөө, Red flags)
- **Хууль, эрх зүйн орчин** (FATF, OFAC, Basel committee, Wolfsberg Group, дотоодын эрх зүйн орчин, оролцогч талууд тэдгээрийн эрх үүрэг, шүүхийн практик)
- **МУТСТ Комплаенсийн хөтөлбөр** (Хэрхэн оновчтой боловсруулах, түгээмэл алдаа, Хэрэглэгчийг таньж мэдэх)
- **Гүйлгээнд хяналт тавих болон мэдээлэх** (Гүйлгээний хяналт, сэжигтэй үйлдлийг илрүүлэх, мэдээлэх, эрсдэлд суурилсан хяналт)
- **Хоригийн хяналт** (Хориг жагсаалтууд, нийцлийг хэрэгжүүлээгүйгээс үүсэх сөрөг үр дагавар, гүйлгээг зогсоох царцаах)

Хэнд зориулагдсан бэ

- Гүйцэтгэх захирлууд
- ТУЗ-ийн гишүүд / Менежерүүд
- Мэдээлэх үүрэг бүхий этгээдийн Комплаенсийн болон МУТСТ хариуцсан ажилтнууд
- Хуульчид, Компанийн хуулийн зөвлөхүүд
- Хууль хэрэгжүүлэгчид
- Энэ чиглэлээр мэргэшихээр сонирхож буй мэргэжилтнүүд



Сургагч багш нар

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Менежер, хуульч
Хуулийн үйлчилгээ



Мөнхжаргал нь PwC Монголын хуулийн үйлчилгээг ахлан ажилладаг 15 гаруй жилийн туршлагатай хуульч юм. Тэрээр МУТСТ, хэрэглэгчийг таньж мэдэх (KYC), эцсийн өмчлөгчийн тогтоох чиглэлээр хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг төдийгүй санхүүгийн байгууллагуудад МУТСТ хөндлөнгийн үнэлгээ хийж байсан арвин туршлагатай. Мөнхжаргал нь PwC Монголын МУТСТ мэргэжилтнээр ажилладаг.

Чулуунбатын Номин-Эрдэнэ

Хуулийн зөвлөх
Хуулийн үйлчилгээ



Номин-Эрдэнэ нь үйлчлүүлэгчдэд комплаенс, МУТСТ болон үнэт цаасны эрх зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажилладаг. Тэрээр мэдээлэх үүрэг бүхий этгээдэд хуулийн зөвлөх, нийцлийн мэргэжилтнээр ажиллаж байсан ба санхүүгийн байгууллагад МУТСТ хөндлөнгийн үнэлгээ хийж байсан туршлагатай.



Сургалтын зорилго

Сургалтад хамрагдсанаар та:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх механизм, түүний үр дагаврыг ойлгох
- МУТСТ-ийг зохицуулж буй олон улсын болон дотоодын эрх зүйн орчны талаар мэдлэг ойлголттой болох
- Үр дүнтэй комплаенсийн хөтөлбөрийг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийг байгууллагадаа хэрхэн хэрэгжүүлэх талаар суралцах
- Гүйлгээний хяналт болон хоригийн хяналтын талаар мэдлэг ойлголттой болох
- МУТСТ хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөхийн ач холбогдол, зөрчлийн үр дагаврыг ойлгох

Дэлгэрэнгүй мэдээлэл

Бүртгэл: 08:45
Сургалт: 09:00 – 13:00
Хэл: Монгол
Байршил: Улаанбаатар зочид буудал

Сургалтын төлбөр

400 000₮ + НӨАТ

Холбоо барих:

+976 7000 9089
mn_academy@pwc.com

Бусад сургалтуудын талаарх мэдээллийг та [ЭНД](#) дарж авах боломжтой

